



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТЭС

**ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2022 ОН

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

НЭГ.Нийтлэг үндэслэл

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ыг үндэслэн УИХ-ын 2020 оны 05 дугаар сарын 13-ны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Орхон аймаг, Эрдэнэт хотын тогтвортой ногоон хөгжлийн бодлого-2025, Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого-2030 зэрэг орон нутгийн болон салбарын стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын цогц үйлчилгээг ухаалаг ажлын байр, цахим засаглал, роботын процесс автоматжуулалтад суурилан олон улсын стандартын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хүргэхэд оршино.

ХОЁР. Мандатын шинжилгээ

Төрийн албаны тухай хууль:

53 дугаар зүйл.Стратеги төлөвлөгөө

53.1.Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

Нийгмийн даатгалын тухай хууль:

24 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэг

Нийгмийн даатгалын байгууллага дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

2/ нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;

3/ нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах;

4/ улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

5/ доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих;

6/ хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

Аудитын тухай хууль

6 дугаар зүйл. Аудитын үйл ажиллагааны зарчим

6.1. Аудитын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

6.1.1. Аудитын олон улсын стандартад заасан арга, хэлбэрээр аудитын үйл ажиллагааг явуулах;

6.1.2. Хараат бус байх, хараат бус байдлыг алдагдуулахад нөлөөлж болох шахалт, эрхшээлд орох аливаа нөхцөл байдлаас зайлсхийх...;

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль

5 дугаар зүйл. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчим

5.1. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална:

5.1.1. үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;

5.1.2. нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;

5.1.3. төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;

5.1.4. судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

5.1.5. нөөц бололцоонд үндэслэсэн байх;

5.1.6. ил тод, нээлттэй байх;

5.1.7. олон нийтийн оролцоог хангасан байх.

6 дугаар зүйл. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөл

6.1. Хөгжлийн бодлогын баримт бичиг нь дэвшүүлж байгаа зорилго, зорилтоосоо хамааран дараах төрөлтэй байна:

6.1.1. урт хугацааны;

6.1.2. дунд хугацааны;

6.1.3. богино хугацааны.

Төсвийн тухай хууль

16 дугаар зүйл. Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрх

16.5.9.дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль

15 дугаар зүйл. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх

1.Өргөдөлд дурдсан асуудлыг шууд шийдвэрлэх боломжтой бол зохих шийдвэрийг гаргана.

2.Шууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал /орон сууц олгуулах гэх мэт/-аар гаргасан өргөдлийг тусгай бүртгэлд бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавина.

3.Гомдлыг албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ.

4.Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн, эсхүл энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээ авсан тохиолдолд энэ тухай хариуг биечлэн амаар буюу харилцах утсаар, эсхүл бичгийн зэрэг тохиромжтой хэлбэрээр мэдэгдэнэ.

5.Хариуг амаар, харилцах утсаар мэдэгдсэн бол энэ тухай бүртгэлд тэмдэглэнэ.

6.Саналын шинжтэй өргөдлийг хүлээн авч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судалсны үндсэн дээр зохих арга хэмжээ авах буюу энэ зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан журмаар хариу өгнө.

20 дугаар зүйл. Өргөдөл, гомдолд судалгаа дүгнэлт хийх

Төрийн байгууллагууд өргөдөл, гомдлын агуулгад судалгаа дүгнэлт хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

УИХ-ын 2020 оны 05 дугаар сарын 13-ны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого

I үе шат (2021-2030): Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх үе.

1.Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ.

2.Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна.

3.Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.

4.Нийгмийн халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг бүрэн хамруулна.

5.Зорилтот, эмзэг бүлгийн өрх, иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг үзүүлдэг болно.

6.Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгоно.

II үе шат (2031-2040): Эрсдэлээс сэргийлсэн нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах үе.

1.Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон байна.

2.Тэтгэврийн нөөц санг ашигт малтмалын орд газрын орлогын өгөөж болон ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдүүлдэг болно.

3.Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжиж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно.

4.Зорилтот, эмзэг бүлгийн хэрэгцээ, орон нутгийн онцлогт нийцсэн халамжийн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлсэн байна.

5.Ахмад настанд урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулсан байна.

III үе шат (2041-2050): Амьдралын чанарыг сайжруулахуйц нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх үе.

1.Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шат эхэлсэн байна.

2.Нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээг өрх, иргэдийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.

УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын Төрийн албаны шинэтгэлийн дүнд хугацааны стратеги”

3.1. Төрийн албаны шинэтгэлийн эрхэм зорилго ба эрхэмлэн дээдлэх зүйлс

Төрийн албаны шинэтгэлийн эрхэм зорилго:

Иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөж буй орчинд уян хатан зохицож чаддаг бөгөөд идэвхитэй, санаачлагатай манлайлагч менежер бүхий цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино.

Төрийн албаны шинэтгэлийн эрхэмлэн дээдлэх зүйлс:

Төрийн үйлчилгээг үр нөлөөтэй хүргэх. Энэхүү эрхэмлэн дээдлэх зүйлс нь төрийн үйлчилгээг хүргэх явдлыг сайжруулах, улмаар ядуурлыг бууруулах стратегийг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болно.

Стратеги зорилт: Төрийн албан хаагч бүрт хамгийн чухал шаардлагатай ур чадвар, тухайлбал төрийн албанд бүхэлд нь хамаарах бодлогын дүн шинжилгээ хийх, эрсдэлийн менежмент, мэдээллийн технологи ашиглах ба хүний нөөцийн удирдлага, түүнчлэн гүйцэтгэлийн удирдлагын ур чадвар эзэмшүүлэх.

УИХ-ын 2015 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 53 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”

Тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын чиглэл

3.1.Тэтгэврийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. хөдөлмөрийн гэрээ, түүнтэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос ажилтан, төрийн албан хаагчид тэтгэврийн даатгалд заавал шимтгэл төлж даатгуулах;

3.1.2.малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчид зориулсан албан журмын тэтгэврийн даатгалын тусгай хөтөлбөр бий болгох;

3.1.3.тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх орлогын дээд хязгаараас давсан өндөр орлоготой даатгуулагч хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд сайн дурын үндсэн дээр даатгуулах нөхцөлийг бүрдүүлэх.

3.2. Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1.тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авах эрх үүсээгүй, амьжиргааны түвшин доогуур, орлогогүй ахмад настанд нийгмийн халамжийн тэтгэвэр олгох;

3.2.2.1960 оноос өмнө төрсөн иргэнд үйлчлэх эв санааны зарчимд үндэслэсэн тэтгэврийн даатгалын хуваарилалтын одоогийн тогтолцоог үргэлжлүүлэн мөрдөж, энэ тогтолцоонд параметрийн шинэчлэл хийх замаар тэтгэврийн сангийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах;

3.2.3.энэ заалтын 3.2.2-т заасан тогтолцооны хүрээнд олгох тэтгэврийн хэмжээг даатгуулагчийн авч байсан цалин хөлс, шимтгэл төлсөн хугацаанд үндэслэн тогтоох;

3.2.4.1960 оноос 1979 оны хооронд төрсөн даатгуулагчид цалин хөлс, шимтгэл төлсөн хугацаанд суурилсан тогтолцоо болон шимтгэлийн хийсвэр нэрийн дансны тогтолцоо /цаашид “нэрийн дансны тогтолцоо” гэх/-ны аль таатай нөхцөлөөр тэтгэврээ тогтоолгох сонголт олгох;

3.2.5.1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийг нэрийн дансны тогтолцоонд үндэслэн тогтоох бөгөөд энэ тохиолдолд тэтгэврийн хэмжээг тэнцвэртэй байлгах зарчмыг баримтлан холбогдох хуульд тухайн үед нь өөрчлөлт оруулах;

3.2.6.даатгуулагч тэтгэвэр тогтоолгох насны хязгаарт хүрч, 10 ба түүнээс дээш жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол өндөр насны тэтгэвэр авах эрхтэй байх;

3.2.7.1979 оноос өмнө төрсөн даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн хэмжээ нь ажилласан жил тутамд дундаж цалин хөлсний хоёр хувиас багагүй байхаар бодож тогтоох;

3.2.8.1979 оноос өмнө төрсөн даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг даатгуулагчийн таван жилийн цалин хөлсний дунджаар тодорхойлж байгааг 2020 оноос нэмэгдүүлж, 2025 он гэхэд даатгуулагчийн 10 жилийн цалин хөлсний дунджийг үндэслэн тодорхойлдог болох бөгөөд цаашид даатгуулагчийн шимтгэл төлсөн нийт хугацааны цалин хөлсний дунджийг үндэслэн тэтгэврийг тогтоох;

3.2.9.1960 ба 1979 оноос өмнө төрсөн даатгуулагч бүрд тэтгэврийн баталгаат хэмжээнээс багагүй тэтгэвэр тогтоож олгох бөгөөд тэтгэврийн баталгаат хэмжээг хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшин, улсын дундаж цалин хөлстэй уялдуулан Засгийн газар жил бүр тогтоох;

3.2.10.тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн ахмад настан бүрд суурь тэтгэвэр олгоно. Суурь тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан Засгийн газраас жил бүр тогтоох бөгөөд суурь тэтгэврийн зардлыг тэтгэврийн даатгалын сан болон улсын төсвөөс хариуцан санхүүжүүлэх;

3.2.11.1979 оноос хойш төрсөн иргэнд үйлчлэх нэрийн дансны тогтолцоо нь шимтгэлийн орлогоороо тэтгэврийн зардлаа нөхдөг хуваарилалтын санхүүжилттэй байх;

3.2.12.нэрийн дансны тогтолцооноос олгох өндөр насны тэтгэврийн хэмжээг даатгуулагчийн төлсөн нийт шимтгэлийн хэмжээ, түүнд бодсон хийсвэр хүү, тэтгэвэр авах хугацааны дундаж илэрхийлэлд үндэслэн тогтоох;

3.2.13.нэрийн дансны тогтолцооноос олгох хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр бодох аргачлалыг шинэчилж, тэтгэврийг даатгуулагчийн цалин хөлс болон шимтгэлтэй уялдаатай байхаар өөрчлөх;

3.2.14.2030 оноос тэтгэврийн даатгалын шимтгэлийг хэсэгчлэн хагас хуримтлалын тогтолцоонд, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх;

3.2.15.тэтгэврийн даатгалын шимтгэл тооцох, тэтгэвэр тогтооход баримтлах цалин хөлс, орлогын доод, дээд хэмжээг Засгийн газар тогтоох;

3.2.16.тэтгэврийн хэмжээг жил бүрийн үнийн өсөлт болон дундаж цалин хөлсний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаж байх;

3.2.17.эдийн засаг, санхүү, хөрөнгийн зах зээлийн урьдчилсан нөхцөл хангагдсан тохиолдолд иргэн бүр сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд хувиараа болон ажил олгогчийн дэмжлэгтэйгээр даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах;

3.2.18. хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг хувийн хэвшлийн тэтгэврийн даатгалын сан ба уг сан бүхий хувийн хэвшлийн урт хугацааны даатгалын компани эрхлэн гүйцэтгэх бөгөөд эрх бүхий байгууллага эдгээр санд тусгай зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

3.2.19. даатгуулагчийн хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд төлөх шимтгэл, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудлыг хуулиар зохицуулах;

3.2.20. хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоо нь бүрэн хуримтлалын байх бөгөөд даатгуулагчийн тэтгэврийн хэмжээ түүний төлсөн шимтгэл, хөрөнгө оруулалтын өгөөжөөс хамаарах;

3.2.21. хувийн хэвшлийн тэтгэврийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын багцыг хянах, хөрөнгө оруулалтын эрсдлийг зохицуулах, хөрөнгө оруулалтын өгөөжийг даатгуулагчийн дансанд шилжүүлэх асуудлыг хуулиар зохицуулах;

3.2.22. цэргийн алба хаасны, нийгмийн халамжийн, 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэний тэтгэврийн зардал болон тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг улсын төсвөөс санхүүжүүлэх.

3.3. Малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчид зориулсан тэтгэврийн даатгалын тусгай сан байгуулж, шимтгэлийн хэмжээ, хугацаа, тэтгэврийн нас болон тэтгэвэр тогтоох, олгох харилцааг тусгай хуулиар зохицуулах;

3.3.2. малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50-иас багагүй хувийг төрөөс хариуцах бөгөөд төрөөс тэтгэврийн даатгалын шимтгэлийг хариуцах хугацааг хуулиар зохицуулах;

3.3.3.тэтгэвэр бодох аргачлал нь энгийн, ойлгомжтой, даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаанаас тэтгэврийн хэмжээ хамаарахаар байх;

3.3.4.нийгмийн даатгалын байгууллага нь тусгай санд шимтгэл цуглуулах үйл ажиллагааг эрхэлж, даатгуулагчийн өөрөө төлсөн шимтгэл болон төрөөс хариуцан төлсөн шимтгэлийг тухай бүр бүртгэж, даатгуулагчид мэдээлэх;

3.3.5.тусгай сангийн хуримтлагдсан хөрөнгийг өсгөн арвижуулах зорилгоор Засгийн газрын бонд, үнэт цаас, бусад эрсдэл багатай банк, санхүүгийн болон хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх.

3.4.Тэтгэврийн нас, тэтгэвэр тогтоох хөнгөлөлттэй нөхцөлийн тухайд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.4.1.хүн амын дундаж насжилттай уялдуулж, тэтгэвэр тогтоолгох насны доод хязгаарыг өөрчлөх асуудлыг судлах;

3.4.2.хүүхэд төрүүлж, хуульд заасан нас хүртэлх хугацаанд асарсан эхчүүдийн хүүхдээ асарсан хугацааг тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласнаар тооцон нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн хугацааг нэмэгдүүлэх;

3.4.3.хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл /газрын доор болон хортой, халуун/-д ажиллагчдын хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоолгосон тэтгэврийн зардлыг тэтгэврийн ердийн нас хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас хариуцах;

3.4.4.хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэврийн ердийн наснаас өмнө тэтгэвэр тогтоох нас, ажилласан жилийн шалгуур болзлыг шинэчилж, хуулиар зохицуулах.

3.5.Тэтгэврийн даатгалын шимтгэлийн талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.5.1.ахмад настны тэтгэврийн үнэлэмжийг сайжруулах, ирээдүйн ахмад настны тэтгэврийн хувь хэмжээг бууруулахгүй байх үүднээс тэтгэврийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үр ашигтай бодлого баримтлах;

3.5.2.малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээг хуулиар зохицуулах;

3.5.3.тэтгэврийн даатгалын шимтгэл ногдуулах, тэтгэвэр тооцох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын доод, дээд хязгаарыг улсын дундаж цалин хөлсний хэмжээтэй уялдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтоох;

3.5.4.хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогч болон даатгуулагчийн харилцан тохиролцсон гэрээгээр зохицуулах.

3.6.Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.6.1.нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь босоо удирдлагатай, улсын хэмжээний бүтэцтэй байх;

3.6.2.аж ахуйн нэгж, байгууллага даатгуулагчийн тооноос хамаарч орон тооны ба орон тооны бус нийгмийн даатгалын ажилтантай байх;

3.6.3.ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлийг бүртгэх, баталгаажуулах, мэдээлэх, нууцлалыг хадгалах үйл ажиллагааг мэдээллийн дэвшилтэт технологи ашиглан гүйцэтгэх мэдээлэл, сургалтын төвийг нийгмийн даатгалын төв байгууллагын харьяанд шинэчлэн зохион байгуулах;

3.6.4.ажил олгогч, даатгуулагч хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд шимтгэл төлөх тохиолдолд шимтгэлээ нийгмийн даатгалын байгууллагаар дамжуулан хувийн хэвшлийн тэтгэврийн даатгалын санд шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.6.5.нийгмийн даатгалын байгууллагын соёлыг хөгжүүлэх, удирдлагын нээлттэй, ил тод үйл ажиллагааг төлөвшүүлэн төсөв, санхүүгийн хариуцлага, дотоод хяналтыг сайжруулах;

3.6.6.нийгмийн даатгалын ажилтныг чадавхижуулах, давтан бэлтгэх, мэргэшүүлэх, тасралтгүй сургах сургалтын нэгдсэн тогтолцоотой болох;

3.6.7.хууль тогтоомжийн биелэлт, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад хяналт тавих, нийгмийн даатгалын үйл ажиллагаа, тайлан мэдээллийг хэлэлцэж,

зөвлөмж гаргах үүрэг бүхий Засгийн газар, даатгуулагч, ажил олгогчийг тэнцүү тоогоор төлөөлсөн зөвлөл байгуулж ажиллах.

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн албаны тухай хуулийн 53.2-т заасан стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Энэ журмыг Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилтуудтай уялдуулан стратеги төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад мөрдөнө.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Нэг. Зорилго

Энэхүү аргачлал нь Төрийн албаны тухай хуулийн 53-р зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах ерөнхий удирдамж болох юм.

Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 13/01 дүгээр тогтоолоор баталсан Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025” бодлогын баримт бичиг

4. Хүний эрх ба хуулийг эрхэмлэн дээдэлж, иргэн-төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурласан нутгийн өөрөө удирдах болон захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагын чадварлаг бүтцийг бүрдүүлж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн, орчин үеийн цахим засаглалыг нэвтрүүлэн, засаглалын бүх шатанд хариуцлага, ил тод байдлыг хангах, иргэн бүрт хүртээмжтэй “Төрийн үйлчилгээний өндөр соёлтой загвар аймаг” болно.

Зорилт 3. Үндэсний онцлог, хүн амын насны бүтцийн өөрчлөлтөд нийцүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.

ГУРАВ. Алсын хараа

Манай байгууллага 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий Даатгагч болно.

ДӨРӨВ. Эрхэм зорилго

Бид Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ.

ТАВ. Орчны шинжилгээ

Орхон аймгийн нийгмийн хэрэгцээ шаардлага:

Аймгийн суурин хүн амын тоо 101652-т хүрч, суурин хүн амын 63.4 хувь нь залуу болон идэр насныхан, 30.3 хувь нь хүүхэд, 6.3 хувь нь ахмад настан байна. Аймгийн хэмжээнд бүтэн өнчин 125, хагас өнчин 1009, 18 хүртэл насны хүүхэдтэй өрх толгойлсон эх 1619, өрх толгойлсон эмэгтэйчүүд 3021 байна.

Өнөөгийн байдлаар 1404 ажил олгогчийн 28864 албан журмын даатгуулагч, 4600 сайн дурын даатгуулагч байна. Эдгээр иргэд нь тус хэлтсийн хэрэглэгч бөгөөд жилд дунджаар давхардсан тоогоор 266.0 мянган иргэн нийгмийн даатгалын үйлчилгээ авч байгаа нь жилийн

өсөлт 77 мянга, цаашид хурдацтай өсөх хандлагатай байна.

Тус аймагт өндөр насны тэтгэвэр 14621, тахир дутуугийн тэтгэвэр авагч 2620, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 719, цэргийн алба хаасны тэтгэвэр авагч 663, ҮОМШӨ-ний ТД, ТА тэтгэвэр авагч 466 нийт 19556 тэтгэвэр авагч байгаа бол ХЧТА-ны тэтгэмж авагч 12900, жирэмсэн амаржсан тэтгэмж авагч 1769, ажилгүйдлийн тэтгэмж 910, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авагч 85258, эмийн хөнгөлөлт авагч 13035 болон жилд дундажаар 462 иргэн оршуулгын тэтгэмж авдаг.

2.ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ БА PESTE анализ

2.1. Нийгмийн орчин

Эдгээр иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэж, иргэдийн цаг хугацаа болон явдал чирэгдлийг хэрхэн багсгах вэ? гэсэн хэрэгцээ нь нийгмийн хамгийн том хэрэгцээ шаардлага болж байна.

Даатгуулагчдын хэрэгцээ, шаардлага, сэтгэл ханамжид нийцүүлэн Нийгмийн даатгалын үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаа, үйл явцыг холбогдох чиглэлийн байцаагч нар үзүүлж байна. Үүнд:

Даатгуулагчдад үзүүлж буй үйлчилгээ:


<ul style="list-style-type: none"> ✓ Өндөр насны тэтгэвэр ✓ Тахир дутуугийн тэтгэвэр ✓ Тэжээгчээ алдсаны тэтгэвэр ✓ Цэргийн тэтгэвэр 	<p style="text-align: center;">Үйлчилгээний тасаг</p> <p style="text-align: center;">Тасгийн дарга-1, Тэтгэврийн 3 байцаагч</p> <p style="text-align: center;">/Үйлчлүүлэгчдийн тоо-18481/</p>
<ul style="list-style-type: none"> ✓ Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, ✓ Жирэмсэн, амаржсаны тэтгэмж ✓ Оршуулгын тэтгэмж ✓ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж ✓ Ажилгүйдлийн тэтгэмж 	<p style="text-align: center;">Үйлчилгээний тасаг</p> <p style="text-align: center;">Тасгийн дарга-1, Тэтгэмжийн 2 байцаагч</p> <p style="text-align: center;">/Үйлчлүүлэгчдийн тоо -13535/</p>

ПРОЦЕСС /иргэдийн хэрэгцээ талаас/

ӨМНӨХ



ДАРААХ



2.2. Эдийн засгийн орчин

Орхон аймгийн төсөв 85.8 тэрбум төгрөг бөгөөд орлогын төлөвлөгөөг 104.7 хувьтай бөгөөд нийт орлого жилд дундажаар 3.7 хувиар нэмэгдэж байна. Орон нутгийн төсвөөс төлөвлөгөөт санхүүжилтийн 95.9 хувь буюу 89.1 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсний 3.2 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 18.2 хувийг бараа үйлчилгээний зардалд, 20.2 хувийг хөрөнгийн зардалд, 28.6 хувийг цалин хөлсөнд, 29.8 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт зарцуулжээ.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 1354 аж ахуйн нэгж, байгууллагын 27837 албан журмын даатгуулагч, 6527 сайн дурын даатгуулагч байна. Эдгээр даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл жилд дундажаар 80 гаруй тэрбум төгрөгийг тухайн ажил олгогчдын холбогдох албан тушаалтан, сайн дурын даатгуулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэн төвлөрүүлдэг. Энэхүү сангийн хөрөнгийг хэрхэн шат дамжлага багатай, хяналттай, чирэгдэлгүй бүрэн дүүрэн төвлөрүүлж, улмаар сайн дурын даатгалын орлогыг нэмэгдүүлэх вэ?

Хэрхэн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын зохист харьцааг бий болгох вэ?

Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт үйлчилгээг найдвартай, зохих хугацаанд нь чирэгдэлгүй бүрэн санхүүжүүлэх вэ? гэсэн хэрэгцээ шаардлагууд эдийн засгийн хувьд гарч ирж байна.

Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагуудыг хуваарилан 6 орлого шимтгэлийн байцаагч, 2 сайн дурын байцаагч хариуцан ажиллаж байсан бол “Ухаалаг ногоон ажлын байр” төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээр Үйлчилгээний хэсэгт ажиллаж байгаа 10 байцаагчаас ажил олгогч даатгуулагч дугаар авч дурын байцаагчаас нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээ авдаг болоод байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь төр засгийн болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын бодлого шийдвэрийг иргэд, олон нийтэд хүргэдэг хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд дээрх субъектийн гаргасан хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангахын сацуу олон нийтэд мэдээлж сурталчлах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

2.3. Улс төрийн орчин

“Алсын хараа-2050” Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Орхон аймаг, Эрдэнэт хотын тогтвортой ногоон хөгжлийн бодлого-2025, Монгол улсын Засгийн газрын болон Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, улсын болон аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, УИХ болон аймгийн ИТХ, Засгийн газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймгийн Засаг даргын бодлого шийдвэрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн иргэдээс ирүүлсэн санал хүсэлтээр нийгмийн даатгалын үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, хүртээмжтэй байдлыг хангах чиглэлээр тодорхой саналууд гарч байна.

*Монгол улсын
Засгийн газрын
2020-2024 оны үйл
ажиллагааны
хөтөлбөрийг
хэрэгжүүлэх арга
хэмжээний
төлөвлөгөөнд:*

1.1.1.2.Нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийг 2020 оны 10 дугаар сараас хойш хэсэгчлэн үргэлжлүүлнэ.

2.5.Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.

2.5.1.Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ.

2.5.2.Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.3.Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ.

2.5.13.Тусгай хэрэгцээ /байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээл/-тэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх боломжоор хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Төсвийн ерөнхийлөн захирагч болон Орхон аймгийн Засаг даргын хооронд хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн талаар 2021 онд байгуулсан гэрээнд:

“Аймгийн Засаг дарга нь Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөдөлмөр, хүн ам, нийгмийн даатгал, халамж, залуучууд, хүүхэд, гэр бүлийн асуудлаарх зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд Төсвийн тухай хууль болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудалтай холбогдсон хууль тогтоомжийн дагуу арга зүй, зохион байгуулалтын шуурхай удирдлагаар хангах, зохицуулах үйл ажиллагааг аймгийн хэмжээнд эрхлэн явуулж гэрээнд заагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээж, түүний үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн өмнө хариуцна”.

2.4. *“Нийгмийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах*

2.5. *Нийгмийн даатгалын үйлчилгээг чанартай хурдан шуурхай хүргэх, тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох”* гэсэн бодлого шийдвэрүүд тус хэлтсийн үйлчилгээний арга хэлбэрийг шинэ шатанд гаргах, төрийн албаны менежментийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага болж байна.

2.4. Технологийн орчин

Орхон аймгийн Нийгмийн даатгалын байгууллагын соёлыг төлөвшүүлэх, менежментийн чадавхийг бэхжүүлэх, иргэдийг эрсдлээс хамгаалах, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээний чанартай, хүртээмжтэй, шуурхай, нээлттэй, ил тод байдлыг хангах, улмаар хүний хөгжлийг хангах зорилгоор “Ухаалаг ногоон ажлын байр” төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг манай байгууллага 2017 оноос эхлэн үе шаттайгаар, холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцүүлэн, иргэд олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж эхэлсэн юм.

Өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагатай холбогдуулан “Ухаалаг ногоон ажлын байр” төслийг боловсруулан танилцуулж байна. Тус хэлтсээс зөвхөн 2017 онд л гэхэд давхардсан тоогоор 266.0 мянган иргэн эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээ авсан гэсэн статистик тоон үзүүлэлт гарсан бөгөөд үүнд мэдээлэл лавлагаа авсан иргэдийн тоо ороогүй болно. Мөн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг хагас, бүтэн жилээр авч байгаа бөгөөд иргэдийн төрийн байгууллагаас хүсэн хүлээж буй зүйл бол аль

болох богино хугацаанд, шат дамжлагагүйгээр үйлчилгээ авах явдал байсаар байна. Энэхүү хэрэгцээ шаардлагыг харгалзан нийгмийн даатгалын 30 төрлийн үйлчилгээг байцаагч бүрт хуваарилан ажиллаж ирснийг 10 байцаагч бүх үйлчилгээ үзүүлдэг болгосон нь цаг хугацааны хувьд эерэг үр нөлөөтэйгээс гадна иргэд даатгуулагчид руу хандсан үйлчилгээ болсон юм.

“Ухаалаг Ногоон-Ажлын байр” төслийг санаачлан хэрэгжүүлж, нийгмийн даатгалын үйлчилгээний менежментийг боловсронгуй болгож, иргэд, даатгуулагчдад хүргэж буй төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх зорилт тавьж ажиллаж байна. Энэхүү төслийн хүрээнд:

Киоск буюу дугаар дуудагч автомат төхөөрөмжөөс иргэд дугаар авч үйлчилгээний хэсгийн дурын байцаагчаар нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүллээ.

Байгууллагын хэмжээнд ашиглаж буй хоорондоо үл хамааралтай олон төрлийн програмуудыг халж, мэдээллийн давхардалгүй нэгдсэн санг бий болгож, бүх түвшинд шуурхай, бодит мэдээ тайланг цаг хугацаанд нь хүргэж, удирдлагын нэгдмэл байдлыг хангаснаар дээр дурдсан бүх төрлийн нөөцийг зөв зохистой, ашигтай төлөвлөж, удирдах боломжийг олгохын тулд ERP, CRM болон процессийн төгөлдөршлийн цахим систем, төхөөрөмжүүдийг ашиглаж эхлээд байна.

Тус хэлтсийн иргэд, олон нийтэд чиглэсэн нэг цэгээс үзүүлж байгаа нийгмийн даатгалын үйлчилгээний жагсаалт:

Үйлчилгээний хэсэг:

- ✓ Эрүүл мэндийн даатгалын дэвтэр баталгаажуулах
- ✓ Нийгмийн даатгалын дэвтэр баталгаажуулах
- ✓ Эрүүл мэндийн даатгалын дэвтэр нээх
- ✓ Нийгмийн даатгалын дэвтэр нээх
- ✓ Сайн дурын даатгалын гэрээ байгуулах
- ✓ Сайн дурын даатгалын гэрээ сунгах
- ✓ Сайн дурын даатгалын гэрээ цуцлах
- ✓ Сайн дурын даатгалын алданги тооцох, салгах,
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эхчүүдийн СДД сунгах
- ✓ Эрүүл мэнд, нийгмийн даатгалтай холбоотой бүх төрлийн зөвлөгөө, мэдээлэл өгөх

- ✓ Эрүүл мэндийн даатгалын сунгалт хийх
- ✓ Ажилгүйдлийн тэтгэмжийн олгох хуудас олгох
- ✓ Ажилгүйдлийн тэтгэмжийн материал хүлээн авах
- ✓ Ажилгүйдлийн тэтгэмжийг зогсоож тооцоог дуусгах
- ✓ Хувийн хэрэг хаах, дэвтэр олгох
- ✓ Аж ахуйн нэгж, байгууллагын тэтгэмжийн материал хүлээн авах
- ✓ ҮОМШӨ-ний сувиллын зардлын материал хүлээн авах
- ✓ Сайн дурын даатгалын ХЧТА хянах
- ✓ СДД-ын жирэмсэн, амаржсаны тэтгэмж хянах
- ✓ Бүх төрлийн тэтгэврийн материал хүлээн авах
- ✓ Зөвшөөрлийн хуудас олгох
- ✓ Банк солих
- ✓ Нас барсан тэтгэвэр авагчийн мэдээлэл шалгах солих бүртгэх
- ✓ Тэтгэвэр авагчдад тодорхойлолт олгох
- ✓ Тэтгэврийн дэвтэр солих шинэчлэх, олгох
- ✓ Тэтгэврийн дэвтэр солих шинэчлэх
- ✓ Эрх үүссэн тодорхойлолт олгох
- ✓ Эрх үүсээгүй тодорхойлолт олгох
- ✓ Архивын лавлагааний захиалга авах
- ✓ Өргөдөл хүлээн авах
- ✓ Аж ахуйн нэгж, байгууллагын тайлан хүлээн авах
- ✓ Өр төлбөртэй эсэх тодорхойлолт олгох зэрэг 30 гаруй төрлийн үйлчилгээг

нэг цэгээс дурын байцаагч үзүүлснээр иргэдийн цаг хугацаа, чирэгдлийг эрс бууруулж байна.

Эрсдэл ба дотоод орчны шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Ажлын хамт олон зохих түвшинд зөв төлөвшсөн, мэдлэг ур чадвар сайн, нэг ажлаас нөгөөд хөрвөх чадвартай • Удирдлагын баг сайн бүрдсэн ба өөрчлөлт шинэчлэлт, менежментийг дэмждэг. • Нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлдэг тул иргэдийн хандлага сайн даатгуулагчдын тоо өсөх хандлагатай • Техник тоног төхөөрөмж, программ хангамж сайн • Хүн бүрийн хийх ажлын чиг үүрэг тодорхой, ажил тогтмолжсон • Байгууллагын дотоод орчны зохион байгуулалт сайн • Жишиг архивтай • “Ухаалаг архив”-ын систем аймагт анх удаа нэвтрүүлж бүтээмжийг нэмэгдүүлсэн. • Архивыг бүрэн эрсдэлээс хамгаалсан 	<ul style="list-style-type: none"> • Хүний нөөцийн дутагдал • Програм хангамж сайн хэдий ч дээд шатны байгууллага, төрийн байгууллагын хоорондын уялдаа холбоо муу • Цалин хангамж, урамшууллын тогтолцоо сул • Шинэ ажилчдын сургалт, хөгжлийн асуудал дутмаг • Хэвлэл мэдээллийн хэрэгслээр реклам, сурталчилгаа муу цацагддаг • Тэтгэмжийн даатгалын сангаас гарсан зардалд тавих хяналт сул • Байгууллага, даатгуулагчийн өмчийг хамгаалах ажил сул • Олон жил хэвшсэн төрийн албаны арга барил өөрчлөгдөхдөө удаан байх • Үйлчилгээний байр танхим дутагдалтай, цахилгаан болон инженерийн шугам хуучирсан.
Боломж	Аюул
<ul style="list-style-type: none"> • Чадварлаг мэргэшсэн баг бүрдүүлэх боломжтой • Хариуцлага, урамшуулалын систем нэвтрүүлэх боломжтой • Иргэд даатгуулагчдын хандлагыг өөрчлөх, Нийгмийн даатгалын тухай хуулийн мэдлэгээр хангах боломжтой • Хамрагдалтыг нэмэгдүүлэх боломжтой • Гадаад харилцааг өргөжүүлэх, туршлага солилцох боломжтой • Үйл ажиллагааны процессыг хөнгөвчлөх боломжтой. • Нийгмийн даатгалын шинэчлэл үйлчилгээ, орчин үеийн менежмент нэвтрүүлэх боломжтой. 	<ul style="list-style-type: none"> • Эдийн засгийн хямрал • Бухимдсан иргэд даатгуулагч байцаагчдад халдах • Нийгмийн даатгалын тогтолцоонд улс төрийн оролцоо нэмэгдэх • Даатгуулагч итгэл алдрах, гомдол гаргах • Иргэд нийгмийн даатгалын талаар буруу мэдээлэл авах бусдад дамжуулах, даатгуулагч хохирох • Интернет, цахим сүлжээгээр эзэнгүй худал мэдээлэл тархах • Байцаагчийн зохимжгүй үйлдлээс шалтгаалан байгууллагын нэр хүнд унах • Байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөж нөлөөлөл бий болох

Стратегийн зорилго

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

/Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс/

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: Нийгмийн даатгалын үйлчилгээ</i>					
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Нийгмийн даатгалын үйлчилгээ</i>					
Зорилт-1. Нийгмийн даатгалын байгууллагын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах"	<u>Арга хэмжээ-1</u> Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах /2015-2030/ бодлогыг аймаг, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх	Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлж, нэмэгдлийг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.	Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулсан.	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, хэрэгжилтийг дүгнэн тайланг НДЕГ-т ирүүлсэн байна.	
	<u>Арга хэмжээ-2</u> Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулан 3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн нийгмийн даатгалын	3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд үлдсэн 50 хувийг даатгуулсан эсэхээс хамаарч	2020 онд шинээр хэрэгжсэн.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулан, хэрэгжилтийг ханган ажилласан байна. /Хамрагдах хүний тоо, орлогын төлөвлөгөө, зарлагын төсвийг	

	<p>шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд үлдсэн 50 хувийг даатгуулсан эсэхээс хамаарч тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс төлүүлсэн, ажил олгогч, даатгуулагч, иргэдэд мэдээлэх, төв орон нутгийн албадыг мэргэжил арга зүйгээр хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.</p>	<p>тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс төлүүлсэн байна.</p>		<p>хуваарийн дагуу биелүүлж ажиллах/</p>	
	<p><u>Арга хэмжээ-3</u> Сайн дурын даатгуулагчид жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 12 сарын орлогын дунджаас 100 хувиар тооцон олгосон байх.</p>	<p>Сайн дурын даатгуулагчид жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 12 сарын орлогын дунджаас 100 хувиар тооцон олгосон байна.</p>	<p>2020 онд шинээр хэрэгжсэн.</p>	<p>Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг хугацаанд нь олгож, гомдол саналгүй ажилласан байна.</p>	
	<p><u>Арга хэмжээ 1.4.</u> Эхчүүдийн хүүхдийн тоогоор ажилласан жилийг нэмэгдүүлэн тэтгэвэр тогтоох</p>	<p>Нийгмийн даагаллын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан</p>	<p>2020 онд шинээр хэрэгжиж эхэлсэн.</p>	<p>Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж өндөр нас, тахир дутуу, тэжээгчээ алдсаны тэтгэврийг хугацаанд нь олгож, гомдол саналгүй ажилласан байна.</p>	

		болзол, нөхцөлийг хангасан даатгуулагч эхэд тэтгэвэр тогтоосон байна.			
